

5275



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

**ЭМ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАРТ**

2023.09.04 № A-1/3614
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ЭЭХХЗГ/202302002 дугаартай “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл арга хэмжээний Багц-2 “Хангамжийн материал” шил сав гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн “Цэцүүх трейд” ХХК-тай 35,686,850.00/гучин таван сая зургаан зуун наян зургаан мянга найман зуун тавь/ төгрөгөөр тендерийн хүчинтэй байх хугацаанд буюу 2023 оны 9 дүгээр сарын 07-ны өдөрт багтаан гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

Үнэлгээний хорооны дүгнэлт, тайлан, холбогдох материалыг хавсаргав.


Хавсралт: 33 хуудастай.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

*Агуулга (Cable)
Судам
М. Энхтүвшин
19/04.*



1323211681



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалт, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2023 оны 01/753 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1."Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

О.Мөнхсоёл

Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Ш.Ариунзаяа

Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Бүртгэлийн хэлтсийн биологийн идэвхит бүтээгдэхүүний бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Цэрмаа

"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" төрийн бус байгууллагын гишүүн

А.Дэмбэрэл

"Худалдан авах үйл ажиллагааны хөтөч" төрийн бус байгууллагын гишүүн

Нарийн бичиг:

Л.Мөнхбаяр


Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсийн мэргэжилтэн

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (О.Мөнхсоёл)-д даалгасугай.

3.Дээрх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбогдох бүх баримт бичгийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 28 хоногийн дотор хадгаламжийн нэгж үүсгэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Л.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэст даалгасугай.

ДАРГА



Ц.БАТЗУЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@sqa.gov.mn
Цахим хуудас: www.sqa.gov.mn

ЦЭЦҮҮХТРЕЙД
ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД

2023.08.23 № A-1/3564
танай _____-ны № _____-т


Гэрээ байгуулах эрх олгох тухай

Тус газраас зарласан ЭЭХХЗГ/202302002 дугаартай "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний Багц № 2: "Хангамжийн материал (шил сав)"-ын 35,686,850.00 (Гучин таван сая зургаан зуун наян зургаан мянга найман зуун тавь) төгрөгөөр тус тус нийлүүлэхээр 2023 оны 8 дугаар сарын 08-ны өдөр ирүүлсэн танай тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзэж, гэрээ байгуулах эрх олгож байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаа буюу 2023 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн дотор гэрээний маягтад гарын үсэг зурж Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт хүргүүлнэ үү.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг мэдэгдэл хүлээн авснаас хойш хуульд заасны дагуу захиалагчид хүргүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болохыг анхаарна уу.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1323211502

ТЕНДЕРИЙН НЭЭЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ, ҮНИЙН САНАЛУУД (Тендерийн нээлт дээр зарлагдсан дүнгээр)

Гэрээний дугаар, нэр: 1 - Өндөр идэвхит шингэний хроматографийн багана

№	Нэр (1)	Тендерийн зарлагдсан үнэ		Бусад мэдээлэл		
		Тендерийн зарлагдсан үнэ	Дүн эсхүл хувь (2)	Үнийн хөнгөлөлт (3)	Хувилбарт тендерийн үнэ (4)	Тендерээ буцааж авсан (5)

Хоосон байна.

Гэрээний дугаар, нэр: 2 - Хангамжийн материал (шил сав)

№	Нэр (1)	Тендерийн зарлагдсан үнэ		Бусад мэдээлэл			
		Тендерийн зарлагдсан үнэ	Дүн эсхүл хувь (2)	Үнийн хөнгөлөлт (3)	Хувилбарт тендерийн үнэ (4)	Тендерээ буцааж авсан (5)	Тендерт нэмэлт, өөрчлөлт хийсэн (6)
1	Редон-Энх	43,818,000	0				Байгаа
2	Мед импекс интернэшл	41,597,500	0				Байгаа
3	Цэцүүхтрейд	35,686,850	0				Байгаа

Үнэлгээний хорооны гишүүд

№	Албан тушаал	Нэр	Гарын үсэг
1.	Үнэлгээний хорооны нарийн бичиг	Л.Мөнхбаяр	
2.	Үнэлгээний хорооны дарга	О.Мөнхсөөл	
3.	Үнэлгээний хорооны гишүүн	Ш.Ариунзала	
4.	Хөндлөнгийн гишүүн	А.Дэмбэрэл	
5.	Хөндлөнгийн гишүүн	Ц.Цэрига	

“ЭМ БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ” ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 31

Дугаар 01

Улаанбаатар хот

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны хурал цахим хэлбэрээр буюу Microsoft “Teams” программыг ашиглан 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 09:00 цагт эхлэв.

Хуралд үнэлгээний хорооны дараах бүрэлдэхүүн оролцов. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга	О.Мөнхсоёл
Нарийн бичиг	Л.Мөнхбаяр
Гишүүд	Ш.Ариунзаяа
	Г.Цэрмаа
	А.Дэмбэрэл

нарын бүрэлдэхүүнтэйгээр 100 хувийн ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгох шалгаруулах тендерийн баримт бичиг боловсруулах.
2. Тендер шалгаруулалтыг зарлах хугацааг хэлэлцэх

Сонссон нь:

Үнэлгээний хорооны дарга О.Мөнхсоёл Үнэлгээний хорооны нарийн бичиг Л.Мөнхбаяр нар Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/155 дугаар тушаал болон захиалагчаас ирүүлсэн албан бичиг, ажлын даалгавартай танилцаж тендерийн баримт бичгийн төслийг урьдчилсан байдлаар боловсруулан үнэлгээний хорооны гишүүдийн саналыг цахим хэлбэрээр авч, тендерийн баримт бичигт тусгав.

О.Мөнхсоёл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан Үнэлгээний хорооны гишүүн буюу захиалагчийн төлөөллөөс техникийн тодорхойлолтоос танилцуулна уу гэж хүсье.

Ш.Ариунзаяа: Сайн байна уу Би захиалагч болох Эм Шинжлэх лабораторийн техник хариуцсан мэргэжилтэн Цогзолмаа байна. Үнэлгээний хорооны гишүүн Ариунзаяа надад хүсэлт тавьж техникийн тодорхойлолтыг мэргэжлийн үндсэн дээр танилцуулж өгөхийг хүссэн учраас хамт энэ хуралд оролцож байна.Бид энэ техникийн тодорхойлолтыг 2 багцтай байдлаар хуваан боловсруулсан.

Багц-1 Өндөр идэвхит шингэний хроматографийн багана

Энэ нь эмийн түүхий эдэд голлон шинжилгээ хийдэг өндөр мэдрэмжит багажид ордог голлох иж бүрдэл юм. Бид 11 ширхэн багана худалдаж авахаар төлөвлөсөн.С-18, С-8, RP-18, RP-8 Зэрэг баганууд нь гадна талаасаа харахад урт төмөртэй төстэй зүйл гэж хэлж болно. Гол үзүүлэлт нь урт, дотоод диаметр, жижиг хэсгийн хэмжээ гэсэн 3 үндсэн үзүүлэлт байна.

Багц-2 Манай байгууллага Химийн болон Микробиологийн гэсэн 2 лабароторитой бөгөөд энэ багц нь шинжилгээнд хэрэглэгддэг туслах материалуудаа багцалсан.

О.Мөнхсоёл: За ойлголоо. Багц-1 ийн С-18 С-8 зэрэг багана гэдэг нь гуурс гэсэн үг юм байна тийм үү

Цогзолмаа: Тийм. Нэг үгээр гуурс гэсэн үг бас шүүлтүүр ч гэж ойлгож болох юм байна.

О.Мөнхсоёл: Тендер шалгаруулалтад хамгийн чухал зүйлс бол багц тус бүрийн үнийн задаргаа байх ёстой. Үнэлгээний хорооны нарийн бичигт цахим шуудангаар боловсруулсан багцуудцын үнийн задаргааг ирүүлсэн. Үнэлгээний хорооны нарийн бичиг тэр материалаа танилцуулаарай.

Л.Мөнхбаяр: Багц-1 38,525,000.00 төгрөгийн дүнтэй

Багц-2 44,475,140 төгрөгийн дүнтэй бөгөөд нийлбэр дүн 83,000,140.00 төгрөгийн дүнтэй болж байна.

О.Мөнхсоёл: За ойлголоо. Үнэлгээний хорооны гишүүн Ариунзаяаг оруулаад хурлаа үргэлжлүүлбэ. Техникийн тодорхойлолтыг мэргэжил арга зүйн үүднээс зөвлөгөө өгч тусласан Цогзолмоо таньд баярлалаа. Үнэлгээний хорооны нарийн бичиг урьдчилан боловсруулсан тендерийн баримт бичгийг гишүүддээ танилцуулан санал сонсоод яваарай.

Л.Мөнхбаяр: Багцад хуваагдах эсэх нь тодорхойгүй байсан ба захиалагчаас тодруулсны үндсэн дээр 2 багцад хуваагдахаар боллоо. Санхүүгийн чадавхийн шалгуур буюу борлуулалтын хэмжээ, гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ зэрэг нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байхаар тусгасан.

Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: “Шаардана”

Борлуулалтын хэмжээ: 2020, 2021, 2022 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.

Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: “Шаардана”

1. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Багцын батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:

- Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/
- Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ.
- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цаас

2. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр, төлбөргүй талзарх тодорхойлолтыг ирүүлнэ.

О.Мөнхсоёл: Дэмжиж байна.

А.Дэмбэрэл: Дэмжиж байна.

Ш.Ариунзаяа: Санал нэг байна.

Г.Цэрмаа: Нэмэлт саналгүй.

О.Мөнхсоёл:

Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: “Шаардана”

Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2020, 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт

оролцогчдын сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.

Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:

Ижил төстэй гэрээний туршлага: 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байх шаардлагатай.

Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн актын хуулбар, тухайн барааг цаг хугацаанд нь чанартай нийлүүлсэн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.

Хянан үзэх санхүүгийн тайлангийн жилийн хугацаа болон ижил төстэй гэрээний туршлага нь 2020, 2021, 2022 онууд байх ба нэг жилд тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байх шаардлагатай гэдэг нь ойролцоогоор 24,000,000 сая гаруй байгаа нь хангалттай гэж үзэж байна.

О.Мөнхсоёл: Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, итгэмжлэл шаардлагатай юу? Урвалж бодис учир шаардлагатай болов уу гэж бодож байна.

Ш.Ариунзаяа: Багц-2 нь хангамжийн шил сав учир шаардлагагүй байх гэж бодож байна.

О.Мөнхсоёл: Хүснэгтийн 18.6 хэсгийг гаргаад Багц 1-ийн тухайд үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээ ирүүлэхийг тусгаж өгөөрэй.

Ш.Ариунзаяа: Ер нь ихэвчлэн нийлүүлж байгаа газрууд нь эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлдэг мэргэжлийн байгууллагууд байдаг учраас асуудалгүй байх.

О.Мөнхсоёл: Энэ төсөл арга хэмжээний хувьд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар явагдана. Үнэлгээний хорооны нарийн бичиг гадаадын этгээд тендер шалгаруулалтад орох эрхгүй гэдгийг тусгаж өгөөрэй. Гишүүд саналаа хэлнэ үү

П.Мөнхбаяр: Ойлголоо. Нэмэлт саналгүй.

А.Дэмбэрэл: Нэмэлт саналгүй дэмжиж байна.

Ш.Ариунзаяа: Дэмжиж байна. Нэмэлт саналгүй.

Г.Цэрмаа: Дэмжиж байна. Нэмэлт саналгүй.

О.Мөнхсоёл: Тендерийн баримт бичиг болон үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үнэлгээний хорооны гишүүдийн санал, зөвлөмжийг тусган боловсруулж дууслаа. Гишүүдийн цахим хаягаар дахин хүргүүлбэ. Та бүхэн саналаа тусгаад эргэн илгээгээрэй. Тендер хүлээн авах хугацааг бүх нийтээр амрах өдөр зэргийг тооцож үзээд хамгийн ойрын боломжтой өдөр зарлахыг үнэлгээний хорооны нарийн бичиг анхаарна уу. Өнөөдрийн үнэлгээний хорооны хурлаар хураангуй жагсаалт үүсгэх, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах хугацаа гэсэн асуудлуудыг хэлэлцэж тохирлоо. Гишүүдэд санал байхгүй бол хурлыг дуусгая. Хуралд оролцсон та бүхэнд баярлалаа.

Шийдвэрлэсэн нь:

1. Төрийн болон орон нутгийн емчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтыг өгөгдлийн хүснэгт, гэрээний тусгай нөхцөлийг зүйл, заалт тус бүрээр хэлэлцэн үнэлгээний хорооны олонхийн саналаар боловсруулав.
2. Төрийн болон орон нутгийн емчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу саналын урилгыг 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр нийтэд зарлан мэдээлж, 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 11.00 цаг хүртэл тендерийн материал хүлээн авч, 11.10 цагт тендерийг нээхээр шийдвэрлэв.


3. "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" ЭЭХХЗГ/202302002 дугаартай тендерийн баримт бичиг нь энэхүү хурлын тэмдэглэлийн салшгүй хэсэг болно.

Хурал 9.40 цагт хаав.


Хурлын тэмдэглэлтэй танилцан, хүлээн зөвшөөрсөн:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА.


ГИШҮҮД:


О.МӨНХСОЁЛ


Ш.АРИУНЗАЯА


А.ДЭМБЭРЭЛ


Г.ЦЭРМАА


Л.МӨНХБАЯР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ:

“ЭМ БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ” ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 07 дугаар сарын 06

Дугаар 02

Улаанбаатар хот

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны хурал цахим хэлбэрээр буюу Microsoft “Teams” программыг ашиглан 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 14:00 цагт эхлэв.

Хуралд үнэлгээний хорооны дараах бүрэлдэхүүн оролцов. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга	О.Мөнхсоёл
Нарийн бичиг	Л.Мөнхбаяр
Гишүүд	Ш.Ариунзаяа
	Г.Цэрмээ
	А.Дэмбэрэл

нарын бүрэлдэхүүнтэйгээр 100 хувийн ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгох шалгаруулах тендерийн баримт бичиг дахин боловсруулах.
2. Тендер шалгаруулалтыг дахин зарлах хугацааг хэлэлцэх

О.Мөнхсоёл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн худалдан авах ажиллагааны газрын дэргын 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан. Бид 2023 оны 07 сарын 06-ны өдөр тендерийн нээлтийг хийхэд оролцогч санал ирүүлээгүй байна.

Л.Мөнхбаяр: Та бүхэнд нээлтийн тэмдэглэлийг харуулъя.

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн үнийн хөнгөлөлт	Тендерийн баталгааны дүн (Хугацаа)
Багц № 1: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана				
1.	-	-	-	-
Багц № 2: Хангамжийн материал (шил сав)				
1.	-	-	-	-

О.Мөнхсоёл: Миний хувд өмнө боловсруулсан тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулалгүй дахин зарлах саналтай байна. Тендер шалгаруулалтыг наадмын амралт эхлэхээс өмнө яаралтай зарлах хэрэгтэй гэж бодож байна.

Ш.Ариунзаяа: Санал нэг байна. Бараа материал нь яаралтай шаардлагатай байгаа тул амралт эхлэхэс өмнө зарлах хэрэгтэй байна.

Л.Мөнхбаяр: Ойлголоо. Нэмэлт саналгүй.

А.Дэмбэрэл: Нэмэлт саналгүй дэмжиж байна. Өмнөх боловсруулсан тендерийн баримт бичгийн дагуу дахин зарлах саналтай байна.

Ш.Ариунзаяа: Дэмжиж байна. Нэмэлт саналгүй.

Г.Цэрмаа: Дэмжиж байна. Нэмэлт саналгүй.

О.Мөнхсоёл: Тендерийн баримт бичиг болон үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үнэлгээний хорооны гишүүдийн өмнө боловсруулсаны дагуу хэвээр үлдээж дахин зарлахаар болов. Гишүүдэд санал байхгүй бол хурлыг дуусгая. Хуралд оролцсон та бүхэнд баярлалаа.

Шийдвэрлэсэн нь:




1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу саналын урилгыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр нийтэд зарлан мэдээлж, 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 11.00 цаг хүртэл тендерийн материал хүлээн авч, 11.10 цагт тендерийг нээхээр шийдвэрлэв.

Хурал 14.20 цагт хаав.

Хурлын тэмдэглэлтэй танилцан, хүлээн зөвшөөрсөн:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:
ГИШҮҮД

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ:

 О.МӨНХСОЁЛ
 Ш.АРИУНЗАЯА
 А.ДЭМБЭРЭЛ
 Г.ЦЭРМАА
 Л.МӨНХБАЯР

**“ЭМ БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ” ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 08 дугаар сарын 17
хот

Дугаар 03

Улаанбаатар

Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 19 ний өдрийн 15:00 цагт цахим хэлбэрээр буюу Microsoft “Teams” программыг ашиглан цахимаар эхлээ.

Хурлын ирц: Хуралд үнэлгээний хорооны дараах бүрэлдэхүүн оролцов. Үүнд:
Үнэлгээний хорооны дарга О.Мөнхсөөл
Нарийн бичиг Л.Мөнхбаяр
Гишүүд Ш.Ариунзаяа
А.Дэмбэрэл

Г.Цэрмаа үнэлгээний хорооны гишүүн хуралд оролцсонгүй. 80 хувийн ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн нарийвчилсан үнэлгээг хийх
2. Хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах, үнэлгээний дүгнэлтийг гаргах

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хэлэлцэх асуудал: “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээг хийх:

СОНССОН НЬ:

Л.Мөнхбаяр: Сайн байцгаана уу? “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний тендерийн нээлтийг товлосон хугацаанд буюу 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 11 цаг 10 минутад нээх үед дараах компаниуд үнийн саналыг ирүүлсэн байна. Үүнд:

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн үнийн хөнгөлөлт	Тендерийн баталгааны дүн (Хугацаа)
Багц № 1: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана				
1.	-	-	-	-
Багц № 2: Хангамжийн материал (шил сав)				

1.	"Мед импекс интернэшнл" ХХК	41,597,600.00	-	Ирүүлсэн
2.	"Радон-Энх" ХХК	43,818,000.00	-	Ирүүлсэн
3.	"Цэцүүхтрөйд" ХХК	35,386,650.00	-	Ирүүлсэн

Л.Мөнхбаяр: "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлтийн тэмдэглэлийг танилцуулж дууслаа.

О.Мөнхсоёл: За ойлголоо. Нээлтийн тэмдэглэлтэй танилцаж дууслаа. Үнэлгээний хорооны гишүүд оролцогч компаниудтай хувийн ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхээ мэдэгдэнэ үү.

Ш.Ариунзаяа: Ашиг сонирхолын зөрчилгүй байна.

А.Дэмбэрэл: Ашиг сонирхолын зөрчилгүй байна.

О.Мөнхсоёл: Ашиг сонирхолын зөрчилгүй байна.

Л.Мөнхбаяр: Миний хувьд мөн адил ашиг сонирхлын зөрчилгүй.

О.Мөнхсоёл: Энэ оролцогчид саналаа ирүүлсэн Багц-2 төсөвт өртөг хэд байсан бэ?

Л.Мөнхбаяр: Нийт төсөвт өртөг 83,000,140 төгрөг бол Багц-2 44,475,140 төгрөг байсан.

О.Мөнхсоёл: Цэцүүхтрөйд ХХК-ийн үнийн санал маш бага байна. Бараа нь чанаргүй байх магадлалтай барааны техникийн тодорхойлолтыг сайн харъя. Нарийн бичиг урьдчилсан үнэлгээг танилцуулна уу.

Л.Мөнхбаяр: Та бүхэнд энэ компанийн ирүүлсэн материалыг танилцуулъя.

"Мед импекс интернэшнл" ХХК

"Мед импекс интернэшнл" ХХК нь Тендер нээсэн өдрийн байдлаар Нийгмийн даатгал болон Татварын өр төлбөргүй. Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлсэн. ТӨХ 18.2-т заасан 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй буюу 13,342,542.00 дээш байх буюу 26.1 тэрбум байна. ТӨХ 18.2.5-т заасны дагуу 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн Худалдаа хөгжлийн банкны ы тодорхойлолтод 4 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгох боломжтой гэсэн тодорхойлолт ирүүлсэн байна.

ТӨХ 18.6-т Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй бараа нийлүүлсэн байх шаардлагыг тавьсан бөгөөд 13,342,542 төгрөгөөс дээш ажлын туршлагатай байх ба оролцогч нь 2021 оны Шүүх шинжилгээний

урвалж бодис, оношлуур, бусад материал нийлүүлэх 129,869,300 төгрөгийн төсөв бүхий гэрээ биелүүлсэн талаарх тодорхойлолт, тус ажлын гэрээ болон бараа хүлээлцсэн акт зэргийг ирүүлсэн байна.ТШЗ 19.5-т заасан Барааны засварын хугацаа нь 12 сар байх бөгөөд албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай гэсний дагуу ирүүлээгүй байна.ТШЗ 20.2-т заасан Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ гэсний дагуу оролцогч маягтын дагуу ирүүлсэн байна.

“Радон-Энх”

“Радон-Энх” ХХК нь Тендер нээсэн өдрийн байдлаар Нийгмийн даатгал болон Татварын өр төлбөргүй. Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлсэн. ТӨХ 18.2-т заасан 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй буюу 13,342,542.00 дээш байх буюу 122,1 сая байна. ТӨХ 18.2.5-т заасны дагуу 2023 оны 07дугаар сарын 31-ний өдрийн Капитрон банкны тодорхойлолтод харилцах дансны 13,505,459 төгрөгийн үлдэгдэлтэй талаар тодорхойлолт ирүүлсэн байна.

ТӨХ 18.6-т Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй бараа нийлүүлсэн байх шаардлагыг тавьсан бөгөөд 13,342,542 төгрөгөөс дээш ажлын туршлагатай байх ба оролцогч нь Ус сувгийн удирдах газартай байгуулсан Шил сав нийлүүлэх 15,400,900 төсөв бүхий гэрээ, гэрээ дүгнэсэн протокол ирүүлсэн ба ирүүлсэн бүхий л ижил төстэй ажлын туршлагад холбогдох материалуудад захиалагчийн тодорхойлолт ирүүлээгүй байна. ТШЗ 19.5-т заасан Барааны засварын хугацаа нь 12 сар байх бөгөөд албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай гэсний дагуу ирүүлсэн байна.ТШЗ 20.2-т заасан Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ гэсний дагуу оролцогч маягтын дагуу ирүүлсэн байна.

“Цэцүүхтрөйд” ХХК

“Цэцүүхтрөйд” ХХК нь Тендер нээсэн өдрийн байдлаар Нийгмийн даатгал болон Татварын өр төлбөргүй. Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлсэн. ТӨХ 18.2-т заасан 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй буюу 13,342,542.00 дээш байх буюу 11,2 тэрбум байна. ТӨХ 18.2.5-т заасны дагуу 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн Голомт банкны 45,000,000 төгрөгийн санхүүжилт олгох боломжтой талаар тодорхойлолт ирүүлсэн байна.

ТӨХ 18.6-т Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо: 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй бараа нийлүүлсэн байх шаардлагыг тавьсан бөгөөд 13,342,542 төгрөгөөс дээш ажлын туршлагатай байх ба оролцогч нь ДЦС-3тай байгуулсан Химийн урвалж шил сав худалдан авах 106,867,050 төгрөгийн төсөв бүхий гэрээ, гэрээ дүгнэсэн акт, захиалагчийн тодорхойлолт ирүүлсэн байна. ТШЗ 19.5-т заасан Барааны засварын хугацаа нь 12 сар байх бөгөөд албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай гэсний дагуу ирүүлсэн байна.ТШЗ 20.2-т заасан Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ гэсний дагуу оролцогч маягтын дагуу ирүүлсэн байна.

О.Мөнхсоёл: Урдчилсан үнэлгээтэй танилцаж дууслаа. "Мед импекс интернэшнл" ХХК-ийн хувьд барааны баталгаат хугацааны мэдэгдэл албан бичгээр гаргаж ирүүлээгүй байгаа

юм байна. "Радон-Энх" ХХК-ийн хувьд захиалагчийн тодорхойлолт дутуу байгаа юм байна. Үнэлгээний хороогоороо эдгээр шаардлагуудыг оролцогчид дутуу ирүүлсэн байгаа эсэхийг дахин нягтлаад санал болгосон барааны жагсаалтыг техникийн тодорхойлолттой харьцуулж нягтлацгаая.

Л.Мөнхбаяр: За ойлголсо. Барааны тодорхойлолт болон "Мед импекс интернэшнл" ХХК-ийн санал болгосон барааны жагсаалт болон ирүүлсэн материалыг харьцуулж харав. Zhejiang Aijireng technology inc буюу БНХАУ-ын үйлдвэрлэгч байгууллагатай хийсэн гэрээ, зөвшөөрлийн бичгийн харж танилцав.

О.Мөнхсоёл: "Мед импекс интернэшнл" ХХК-ийн ирүүлсэн саналаас Барааны баталгаат хугацаа нь 12 сар байх бөгөөд албан бичгээр баталгаажуулан ирүүлэх шаардлагатай гэсний дагуу ирүүлээгүй тул татгалзах саналтай байна. Та бүхэн юу гэж болож байна.

А.Дэмбэрэл: Миний хувьд адилхан татгалзах саналтай байна. Бараа материал нийлүүлэх учраас баталгаат хугацааны албан бичиг хамгийн чухал шүү дээ.

Л.Мөнхбаяр: Миний хувьд санал нэг байна.

Ш.Ариунзаяа: Би шууд санал нийлэх боломжгүй байна. Ирүүлсэн бусад оролцогчдын санал болгож байгаа барааны тодорхойлолттой танилцсаны дараа саналаа хэлмээр байна.

О.Мөнхсоёл: За ойлголоо. Миний хувьд ч гэсэн дахин харах саналтай байна.

Л.Мөнхбаяр: "Радон-Энх" ХХК-ийн хувьд БНХАУ-ын ЭМӨЗО-ны Хөх хотын YI MAN гэсэн үйлдвэрлэгчтэй бараа материал худалдан авахаар байгуулсан гэрээг ирүүлсэн. *Бараа материалын жагсаалтыг танилцуулав.*

Л.Мөнхбаяр: Цэцүүхтрөйд ХХК нь мөн адил БНХАУ-ын Янгченг кордиал медлаб технологи ХХК-с үйлдвэрлэгчийн итгэмжлэлийн бичиг ирүүлсэн байна.

Л.Мөнхсоёл: Баталгааны хугацааг 12 сар байхыг албан бичгээр гарган ирүүлсэн байдлыг нь харъя.

Л.Мөнхбаяр: Үнэлгээний хорооны гишүүд Цэцүүхтрөйд ххк-ийн материалыг дахин хянаж үзэв./

О.Мөнхсоёл: За бид дахин танилцаж дууслаа. Одоо саналаа хэлцгээгээрэй. Захиалагч юу гэж бодож байна.

Ш.Ариунзаяа: Энэ удаад л анх тендер шалгаруулалтаар шил сав бараа материалаа авч байгаа юм байна. Мэдээлэл өгөх үүднээс хэлэхэд өмнө нь худалдан авалтаар авчихдаг байсан ба Радон Энх ХХК-с худалдаж авдаг байсан юм байна.

О.Мөнхсоёл: Бид сая үйлдвэрлэгчдийг нь харахад Радон-Энх ХХК Хөх хотоос нийлүүлэх юм байна. Мөн захиалагчийн тодорхойлолт ирүүлээгүй учраас Радон Энх ХХК-ийн ирүүлсэн саналаас татгалзах саналтай байна. Мөн "Мед импекс интернэшнл"-ийн хувьд

баталгаат засварын хугацаа 12 сар байх бөгөөд албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай гэснийг ирүүлээгүй тул татгалзах саналтай байна.

Ш.Ариунзаяа: Санал нэг байна.

Л.Мөнхбаяр: Миний хувьд мөн адил санал нэгтэй байна.

А.Дэмбэрэл: Дэмжиж байна. Адил саналтай байна.

Үнэлгээний хороо дээрх төсөл, арга хэмжээний үнэлгээг хийж дууслаа. "Цэцүүхтрөйд" ХХК-ийн тендерийг хуралд оролцсон гишүүдийн 100% саналаар хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн гэж үзлээ.

О.Мөнхсоёл: Үнэлгээний хорооны хуралд 100 хувийн саналаар холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Хуралд оролцсон та бүхэндээ баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн саналаар "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад "Цэцүүхтрөйд" ХХК-ийн ирүүлсэн тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг захиалагчид хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн саналаар XI.3.2 "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад "Мед импекс интернэшнл" ХХК, "Радон-Энх" ХХК-иудын ирүүлсэн тендерүүдээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн дагуу шаардлагад нийцээгүй гэж үзэн татгалзахаар шийдвэрлэв.

3. Үнэлгээний тайлан, дүгнэлтийг дахин боловсруулан захиалагчид хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг Л.Мөнхбаярт даалгав.




Хурал 15.54 цагт хаав.

Хурлын тэмдэглэлтэй танилцан, хүлээн зөвшөөрсөн:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

О.МӨНХСОЁЛ

ГИШҮҮД:

 Ш.АРИУНЗАЯА
 Г.ЦЭРМАА
 А.ДЭМБЭРЭЛ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН
БИЧИГ

 Л.МӨНХБАЯР

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

**ЭМ БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ТАЙЛАН, ДҮГНЭЛТ
БАГЦ-1, БАГЦ-2**

**Тендер шалгаруулалт/
гэрээний нэр:**

Дугаар:

**"Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга
хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах**

ЭЗХХЗГ/202302002

**УЛААНБААТАР ХОТ
2023 ОН**

**“ЭМ, БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ” НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ТАЙЛАН, ДҮГНЭЛТ**
Багц № 1: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана
Багц № 2: Хангамжийн материал (шил сав)

Дугаар 01

2023 оны 08 дугаар сарын 21

Улаанбаатар хот

1. ТАНИЛЦУУЛГА

Захиалагч буюу “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас албан бичгээр техникийн тодорхойлолт болон бусад холбогдох баримт бичгийг ирүүлснийг үндэслэн Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/199 дүгээр тушаалаар үнэлгээний хороог байгуулсан.

2. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Сангийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 144 дүгээр тушаалын 1 дүгээр хэсгээр батлагдсан “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийг ашиглан тендерийн баримт бичгийг боловсруулсан.

Тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид хууль гэх/” болон Сангийн сайдын 2012 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 03 дугаар хэсгээр баталсан “Тендерийн үнэлгээний зааврын дагуу үнэлнэ.

3. ТЕНДЕР ЗАРЛАХ БА ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ

